



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 413

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 заалт, Засгийн газрын 2013 оны 374 дугаар тогтоол "Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөлийн үнэлгээний журам"-ын 3.1 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлалыг хавсралтаар баталсугай.

2. Аргачлалын дагуу Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх, мэргэжилтнүүдийг сургах, мэдээлэлээр хангах ажлыг зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг)-д даалгасугай.

3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжиж байгаа үйл ажиллагаанд хийгдэж байгаа эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээнд уг аргачлалыг ашиглах, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-д даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын 2014 оны 12 дугаар сарын  
02 өдрийн 413 дугаар тушаалын хавсралт



## Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал

### А. Ерөнхий хэсэг

Эрүүл Мэндийн Нөлөөллийн Үнэлгээ (ЭМНҮ) нь үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрүүл мэндийн эерэг, сөрөг нөлөөлөл, эрүүл мэндийн тэгш байдлыг урьдчилан тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, эерэг нөлөөллийг дэмжин дэлгэрүүлэх үйл ажиллагааг төлөвлөх үйл явц юм.

Олон салбар, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас нийт хүн ам, хүн амын тодорхой бүлгүүд болон хувь хүний эрүүл мэндэд янз бүрийн нөлөөлөл үзүүлж байна.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний энэхүү баримт бичиг нь Монгол улсад хэрэгжүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээ, эдийн засгийн болон нийгмийн салбарын үйл ажиллагаанд эрүүл мэндийн асуудлыг тусгах, эрүүл мэндийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг орчны эрүүл ахуйч, хөдөлмөрийн эрүүл ахуйч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн хийнэ.

Аргачлалын үндсэн зорилтууд:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үзэл баримтлал, ерөнхий суурь ойлголт болон үнэлгээг хэрэглэх арга зүйгээр хангах;
2. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийхэд түгээмэл ашигладаг арга, хэрэгслийг танилцуулж, нэвтрүүлэх;
3. Монгол улсад мөрдөх эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний ерөнхий багцыг тодорхойлох.

Аргачлалыг дор дурьдсан хэрэглэгчид ашиглана:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний шинжээчид, хяналт үнэлгээний мэргэжилтнүүд;
2. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг захиалагчид, бодлого боловсруулагчид, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэгчид.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал нь тусгай хууль, журам, стандартаар зохицуулагддаг боловч эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээнд ажилчдын

эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлыг шинжилж, хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээг оруулж болно.

## **Б. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний хураангуй**

### **1-р үе шат. Төлөв байдлын шинжилгээ**

Энэ шатанд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд нөлөөлөл үзүүлэх эсэхийг тодорхойлж дараах дүгнэлтийг гаргана.

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүнийн эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй, цаашид үнэлгээ хийх шаардлагагүй
2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүнийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэлм дараах үнэлгээний аль нэг тохирсон үнэлгээг хийнэ.  
Үүнд:
  - а) Хүний эрүүл мэндэд нөлөөлөх эрсдэл бага байвал түргэвчилсэн үнэлгээ хийнэ
  - б) Хүний эрүүл мэндэд учирч болох нөлөөлөл өндөр байвал цогц нарийвчилсан үнэлгээ хийнэ.

Нэгдүгээр үе шатанд гарах бичиг баримт

1. Санал болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны төлөв байдлын шинжилгээний тайлан
2. Эрүүл мэндийн нөлөөллийн талаар мэргэжлийн багийн гишүүдийн дүгнэлт
3. Холбогдох талууд болон орон нутгийн иргэдийн санал

### **2-р үе шат. Цар хүрээг тодорхойлох**


Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг тодорхойлно. Цар хүрээг:

1. Цар хүрээ бага, нөлөөлөл бага
2. Цар хүрээ бага, нөлөөлөл өндөр
3. Цар хүрээ өргөн, нөлөөлөл багатай
4. Цар хүрээ өргөн, нөлөөлөл өндөр гэж ангилан үзнэ.

Хоёрдугаар үе шатанд гарах бичиг баримт

1. Санал болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг тогтоосон дүгнэлт
2. ЭМНҮ-ний ажлын даалгавар, удирдамж

3. Холбогдох талуудыг оролцуулан боловсруулсан хамтын ажиллагааны төлөвлөгөө
4. 2-р үе шатанд гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайлан



### 3-р үе шат. Дүн шинжилгээ

Энэ шатанд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг шинж чанар, ач холбогдлоор нь эрэмбэлнэ. Үүнд:

1. Нөлөөлөл маш бага – нөлөөллийг тодорхойлох боломжгүй
2. Нөлөөлөл бага – нөлөөллийг тодорхойлох боломж бага зэрэг
3. Нөлөөлөл дунд зэрэг – нөлөөллийг тодорхойлох боломж дунд зэрэг
4. Нөлөөлөл их – нөлөөллийн шинж тэмдэг илэрхий гарч ирнэ

Гуравдугаар үе шатанд гарах бичиг баримт

1. Төлөв байдлын шинжилгээ болон цар хүрээг тодорхойлох үе шатанд гүйцэтгэсэн үйл ажиллагааны дүгнэлт
2. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн шинж чанар, ач холбогдлыг эрэмбэлэн тогтоосон хүснэгт
3. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулах зөвлөмж
4. Төслийн дүн шинжилгээний тайлан

**4-р үе шат.** Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үр дүнг нягтлан хянах, мэдээллэх.

Энэ шатанд эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үйл явцыг баримтжуулан тайланд тусгаж, үнэлгээний үнэн бодит байдлыг хянаж, нээлттэй ил тод байдлаар хийгдсэн эсэхийг тодорхойлно. Үүнд:

1. ЭМНҮ- хангалттай хийгдсэн
2. ЭМНҮ- хангалтгүй хийгдсэн
3. ЭМНҮ- хийгдээгүй

Дөрөвдүгээр үе шатанд гарах бичиг баримт

1. ЭМНҮ-ний үйл явцыг баримтжуулан нэгтгэсэн тайлан

**5-р үе шат.** Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг бие даасан байдлаар эсвэл байгаль орчны болон нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг байдлаар боловсруулна.

Тавдугаар үе шатанд гарах бичиг баримт

1. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө
2. Холбогдох талууд болон орон нутгийн иргэдийн санал

**6-р үе шат.** Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт, үнэлгээ

Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргана. Дүгнэлтэнд:

1. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалттай
2. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй аль нь болохыг тодорхойлно.

Зургаадугаар үе шатанд гарах бичиг баримт

1. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт, үнэлгээний тайлан

## В. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ хийх үе шатуудын дэлгэрэнгүй аргачлал

### 1 дүгээр үе шат. Төлөв байдлын шинжилгээ

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний эхний үе шатанд төлөв байдлын шинжилгээ хийнэ. Төлөв байдлын шинжилгээ нь үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, эрсдлийг тодорхойлох урьдчилсан үе шат юм.

Энэ шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд эрсдэл учруулах эсэхийг урьдчилан тодорхойлно.

Төлөв байдлын шинжилгээ нь дараах дүгнэлтүүдийг гаргана:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй, цаашид үнэлгээ хийх шаардлаггүй
2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага, түргэвчилсэн үнэлгээ хийх шаардлагатай
3. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл их, нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай
4. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүний эрүүл мэндэд ноцтой нөлөөлнө, төслийг зогсоох шаардлагатай

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний нэгдүгээр үе шат нь 5 үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үйл ажиллагаанаас гарах үр дүн болон бүрэлдэхүүн хэсгийг тус бүрт нь тусгасан байна.

### Хүснэгт 1.1.Төлөв байдлын шинжилгээ хийх шатлал

	Үйл ажиллагаа	Үр дүн / бүрэлдэхүүн хэсэг
1.	Мэргэжлийн баг бүрдүүлэх (6-7 хүнтэй)	<ul style="list-style-type: none"> <li>• Орчны ба хөдөлмөрийн эрүүл ахуйч,</li> <li>• Химич-шинжээч,</li> <li>• Хор судлаач,</li> <li>• Нийгэм-эдийн засгийн шинжээч,</li> <li>• Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн</li> <li>• Байгаль орчны шинжээч</li> <li>• Тухайн үйл ажиллагаа явуулах салбарын шинжээч</li> </ul>
2.	Холбогдох баримт бичиг судлах	<ul style="list-style-type: none"> <li>• Хууль</li> <li>• Стандарт</li> <li>• Судалгаа, үнэлгээний тайлан</li> </ul>
3.	Санал болгож буй	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь</li> </ul>

	төслийн загварын талаар шаардлагатай мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх	<p>хуулийн дагуу ажиллах боломжтой эсэх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь стандартад нийцсэн эсэх</li> <li>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь судалгаа, үнэлгээний тайлан ашигласан эсэх</li> <li>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжих газар зүйн байрлал, /суурьшилын бүсээс эрүүл ахуйн хамгаалалтын бүс ямар хэмжээнд байгааг/</li> <li>• Дэд бүтэц, хүн амын бүлэгт сөргөөр нөлөөлөх эсэх</li> </ul>
4.	Төслийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхой судлах	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн суурь үзүүлэлт</li> <li>• Эрүүл мэндэд үзүүлж болох нөлөөллийн нотолгоо</li> <li>• Өртөмхий бүлгийг хамруулах</li> <li>• Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлсэд үзүүлэх нөлөөлөл</li> </ul>
5.	ЭМНҮ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанд эрүүл мэндийн нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай эсэх талаар гаргасан шийдвэр;</li> <li>• Төлөв байдлын шинжилгээний үр дүнгийн тайлан, эсхүл бүртгэл/илтгэх хуудас</li> </ul>

Үнэлгээний энэ шатанд санал болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны төлөв байдлын шинжилгээний тайланг боловсруулсан байна. Тайланд дор дурьдсан үйл ажиллагаанууд тусгагдана.

#### **Үйл ажиллагаа 1. Мэргэжлийн баг бүрдүүлэх.**

Төлөв байдлын шинжилгээг мэргэжлийн шинжээчдээс бүрдсэн баг хийнэ. Багийн бүрэлдэхүүнд эрүүл ахуйч, химич-шинжээч, хор судлаач, нийгэм-эдийн засгийн шинжээч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн/шинжээч, байгаль орчны шинжээч болон тухайн үйл ажиллагаа явуулах салбарын шинжээчид байна. Багийн бүрэлдэхүүн 6-7 хүнтэй байна. Жишээ нь, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх байгууламж барих санал гаргасан төслийн ЭМНҮ хийх мэргэжлийн багт хүнсний эрүүл ахуйч заавал байх ёстой.

#### **Үйл ажиллагаа 2. Холбогдох баримт бичиг судлах.**

Мэргэжлийн баг нь төслийн хэрэгжилттэй холбоотой Монгол Улсын хууль, тогтоол, стандарт, судалгаа, үнэлгээний тайланг цуглуулж, шаардлагатай заалтуудыг

нарийвчлан судална. Баримт бичиг судлах үйл ажиллагаанаас гарсан дүгнэлт, мэдээллийг ЭМНУ-ний тайланд тусгасан байна.

**1.3 Үйл ажиллагаа 3.** Санал болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны талаар шаардлагатай мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх.

Санал болгож буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны баримт бичигтэй танилцаж, Хүснэгт 1.2-т заасны дагуу багийн гишүүн тус бүр дүгнэлт гаргаж нэгтгэнэ.

Хүснэгт 1.2. Дүн шинжилгээ хийх үзүүлэлтүүд

	Үзүүлэлтүүд	Т ийм	Ү гүй	Шаардагдах материал	Үндэсл эл, тайлбар
1.	Хуулийн дагуу ажиллах боломжтой эсэх			Мөрдөж буй хууль эрх зүйн актын жагсаалт	
2.	Үйл ажиллагааны загвар нь стандартанд нийцсэн эсэх			Мөрдөж буй стандартын жагсаалт	
3.	Судалгаа, үнэлгээний үр дүнг тусгасан эсэх			Судалгаа, үнэлгээний тайлангийн жагсаалт	
4.	Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авсан эсэх			Сөрөг нөлөөллийг бууруулах ажлын төлөвлөгөө	
5.	Нөлөөлөлд өртөх магадлалтай газар зүйн байрлал, хүн амын бүлгүүдийг тогтоосон эсэх			Хүн амын бүлгүүдийг тогтоосон газар зүйн зураглал	

Нөлөөлөлд өртөх магадлалтай газар зүйн байрлал, дэд бүтэц, хүн амын бүлгүүдийн талаарх мэдээллийг Хүснэгт 1.3-т заасан үзүүлэлтийн дагуу бэлтгэж, нэгтгэнэ.

Хүснэгт 1.3. Газар зүйн байрлал, дэд бүтэц, хүн амын бүлгүүдийг тодорхойлох үзүүлэлтүүд

Газар зүйн байрлал, дэд бүтэц	Хүн амын бүлгүүд
<p>Бүс нутаг Байршил</p> <ul style="list-style-type: none"> <li>• хөдөө</li> <li>• хот</li> <li>• суурин газар</li> </ul> <p>Орон сууц</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон сууцны хангамжийн хүрэлцээ</li> <li>• Орон байрны эрүүл ахуйн шаардлага</li> <li>• Оршин суух газар- кэмп</li> <li>• Түр оршин суух байрны эрүүл ахуйн шаардлага</li> </ul> <p>Орчин</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гадаад орчны агаар, хөрс, усны бохирдолт /химийн хортой бодис, биологийн бохирдуулагчдын түвшин/</li> <li>• Дотоод болон гадаад орчны агаар дахь үзүүлэлтийн хэмжээ</li> <li>• Орчны дуу шуугианы түвшин</li> <li>• Ионжуулагч ба ионжуулагч бус цацрагийн өртөлт</li> <li>• Байгалийн гамшигийн эрсдэл ба хариу арга хэмжээ</li> </ul> <p>Дэд бүтэц:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Усны эх үүсвэр, ус хангамжийн систем</li> <li>• Холбоо, эрчим хүч, шугам сүлжээ</li> <li>• Барилга, бүтээн байгуулалтын хотхон</li> <li>• Замын дэд бүтэц хөгжсөн байдал</li> <li>• Нийтийн тээвэр, машины зогсоол</li> <li>• Үйлчилгээний газрууд</li> <li>• Боловсрол, соёл, хүүхдийн байгууллага</li> <li>• Нийтийн зам тээвэр</li> </ul>	<p>Хүн амын суурь үзүүлэлт :</p> <ul style="list-style-type: none"> <li>• хүн амын тоо</li> <li>• насны ангилал</li> <li>• хүйс</li> <li>• боловсрол</li> <li>• яс үндэс</li> <li>• нийгмийн гарал</li> <li>• боловсролын түвшин</li> <li>• ажил эрхлэлт</li> <li>• нягтаршил</li> <li>• улс төрийн оролцоо</li> <li>• оршин сууж байгаа орчин</li> </ul>

<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж</li> <li>• Цэцэрлэгт хүрээлэн</li> <li>• Хатуу, шингэн хог хаягдлын менежмент</li> </ul>	
--	---

**Үйл ажиллагаа 4.** Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндэд учирч болох нөлөөллийг судлах.

Мэргэжлийн багийн гишүүд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийн талаарх дүгнэлт гаргахдаа холбогдох оролцогч талууд болон орон нутгийн иргэдийн төлөөллийг хамруулж, тэдгээрийн санал бодлыг тусгана. Санал, бодлыг ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын аргыг ашиглан авна. Мэргэжлийн багийн гишүүд ярилцлагын асуултуудыг урьдчилан бэлтгэж, тэмдэглэл хөтөлж, ЭМНУ-ний тайланд хавсаргана. Ярилцлаганд ашиглах асуултуудыг Хүснэгт 1.4-т дурьдав.

Хүснэгт 1.4. Оролцогч талууд болон орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй ярилцах жишээ асуултууд

Асуултууд
Хэрэгжүүлж буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан уу?
Хэрэгжүүлж буй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүний эрүүл мэндэд ямар нөлөөлөл үзүүлэх вэ?
Нутагшмал болон хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт болон халдварт бус өвчний тархалт яаж өөрчлөгдөх вэ?
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь эрүүл мэндийг тодорхойлогч нийгмийн болон орчны хүчин зүйлсэд нөлөөлөх үү?
Хэрэв тийм бол ямар хүчин зүйлд нөлөөлөх болон эрүүл мэндийн ямар үр дагавар гарах вэ? Хувь хүний зан үйлд хэрхэн нөлөөлөх вэ? Жишээ нь хооллолт, дасгал хөдөлгөөн, тамхи таталт, согтууруулах ундааны хэрэглээ, бусад буруу зуршил гэх мэт.
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь хүмүүсийн амьжиргааны түвшин, тэгш бус байдал, нягтаршилд нөлөөлөх үү?
Хэрэв тийм бол хэрхэн нөлөөлөх вэ?
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн үйлчилгээ, боловсрол, дэд бүтцэнд (нийтийн зам тээвэр, эрүүл мэндийн тусламж, цэцэрлэгт хүрээлэн, олон нийтийн газар, ус ба хог хаягдлын систем, орон байр, ус, хөрс, агаарын чанар, орчны шуугиан гэх мэт) нөлөөлөх үү?

Хэрэв тийм бол яаж нөлөөлөх вэ?
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанд улс төрийн оролцоо бий юу? Хэрэв тийм бол ямар оролцоо байна вэ?
Эрүүл мэндийн тэгш бус байдалд нөлөөлөх үү? Хэрэв тийм бол ямар замаар, яагаад?
Энэхүү үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай юу?
Хүн амын ямар бүлэг нь илүү өртөх вэ? Яагаад?

Дээр дурьдсан үйл ажиллагааны хүрээнд мэргэжлийн багийн гишүүд холбогдох баримт бичиг, судалгааны тайланг ашиглахад анхаарна. Хүснэгт 1.5-т заасан шалгуурын дагуу үнэлгээний багийн гишүүн тус бүр оноо өгнө.


Хүснэгт 1.5. Үйлдвэр, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох

	Үзүүлэлтүүд	Шалгуур оноо	Оноо өгсөн үндэслэл, тайлбар
1.	Эрүүл мэндийн суурь үзүүлэлт –хүн амын тоо, дундаж наслал, өвчлөл, нас баралтын тоо, эх, хүүхдийн эндэгдэл, төрөлт гэх мэт үзүүлэлтийг тооцоолно	1 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт сайжирна 2 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт өөрчлөгдөхгүй 3 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт буурна 4 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт ноцтой өөрчлөгдөж, буурна	
2.	Эрүүл мэндэд үзүүлж болох нөлөөлөл	1 оноо – тухайн хүн амын эрүүл мэндэд зэрэгээр нөлөөлнө 2 оноо – тухайн хүн амын эрүүл мэндэд нөлөөлөхгүй 3 оноо – тухайн хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө	

		4 оноо – тухайн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэнэ	
3.	<p>Өртөмхий бүлэг – энэ бүлэгт дараах хүмүүсийг хамруулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- өндөр настан</li> <li>- эмэгтэйчүүд</li> <li>- ажилгүйчүүд</li> <li>- гэр оронгүй хүмүүс</li> <li>- орлого багатай иргэд</li> <li>- өсвөр үеийнхэн гм</li> </ul>	<p>1 оноо – тухайн хүн амын дундах өртөмхий/эмзэг бүлгийн хүмүүст нөлөөлөхгүй</p> <p>2 оноо – тухайн хүн амын дундах өртөмхий/эмзэг бүлгийн хүмүүс нөлөөлнө, тоо нь нэмэгдэхгүй</p> <p>3 оноо – тухайн хүн амын дундах өртөмхий/эмзэг бүлгийн хүмүүсийн тоо нэмэгдэнэ</p> <p>4 оноо – тухайн хүн амын дундах өртөмхий/эмзэг бүлгийн хүмүүсийн тоо эрс нэмэгдэнэ</p>	
4.	<p>Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлсэд үзүүлэх нөлөөлөл – үүнд</p> <ul style="list-style-type: none"> <li>• хувь хүний эрүүл зан үйл</li> <li>• оршин сууж, амьдарч байгаа орчин</li> <li>• Нийгмийн</li> <li>• Эдийн засгийн</li> <li>• Орчны үзүүлэлтүүд хамаарна</li> </ul>	<p>1 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд эерэгээр нөлөөлнө</p> <p>2 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд нөлөөлөхгүй</p> <p>3 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд сөргөөр нөлөөлнө</p> <p>4 оноо – тухайн хүн амын эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд ноцтой нөлөөлнө</p>	

**Үйл ажиллагаа 5. ЭМНҮ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлох**

Мэргэжлийн багийн гишүүд нь санал үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны талаар хийсэн төлөв байдлын шинжилгээний дүгнэлтийг Хүснэгт 1.6-д заасан онооны дагуу гаргана.



Хүснэгт 1.6.ЭМНҮ-ний төлөв байдлын шинжилгээг дүгнэх оноо

	Дүгнэлт	Он оо	Мэрг эжлийн багийн гишүүдийн өгсөн оноо
1.	Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй, цаашид үнэлгээ хийх шаардлагагүй	1	
2.	үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл бага, цаашид түргэвчилсэн үнэлгээ хийх шаардлагатай	2	
3.	Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл их, цаашид нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	3	
4.	үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл маш их учраас төслийг зогсоох шаардлагатай	4	

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний мэргэжлийн баг нь тайлан гаргана. Тайланд үнэлгээний түргэвчилсэн эсхүл нарийвчилсан аргыг санал болгоно. Үнэлгээний аргуудын талаарх товч мэдээллийг Хүснэгт 1.7-д дурьдав.

Хүснэгт 1.7 Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний аргууд

	Түргэвчилсэн ЭМНҮ	Нарийвчилсан ЭМНҮ
Тодорх ойлолт	Түргэвчилсэн үнэлгээ нь бэлэн мэдээ, тоо баримтад тулгуурлаж хийгдэнэ.	Нарийвчилсан үнэлгээг шинээр мэдээлэл цуглуулж хийнэ. Үнэлгээнд орон нутгийн

	Түргэвчилсэн ЭМНҮ	Нарийвчилсан ЭМНҮ
	<p>Түргэвчилсэн үнэлгээг оролцогч талтай буюу оролцогч талгүйгээр хийж болно.</p> <p>Оролцогч талгүй түргэвчилсэн үнэлгээ нь төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл болон төслийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох зорилготой юм. Уг үнэлгээ нь төлөв байдлын шинжилгээ хийхтэй адил боловч ЭМНҮ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлдоггүйгээрээ ялгаатай.</p> <p>Оролцогч талтай түргэвчилсэн үнэлгээ гэдэг нь оролцогч талууд болон үнэлгээний мэргэжилтнүүдийг оролцуулан хийсэн түргэвчилсэн үнэлгээ юм. Уг үнэлгээ нь хурдан, зардал багатай боловч багийн хамтран ажиллах чадварыг шаарддаг.</p>	<p>иргэдээс авсан судалгаа, ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлсэн төслийн эрүүл мэндийн нөлөөллийн байдалд хийсэн судалгаа болон бусад мэдээллийн эх сурвалжийг ашиглаж болно.</p> <p>Энэ үнэлгээнд санхүү, хүний нөөц, цаг хугацаа шаардагддаг.</p>
Цаг хугацаа	<p>Оролцогч талгүй: Хэдэн цагаас хэдэн өдөр</p> <p>Оролцогч талтай: 1-2 сар</p>	1 жил хүртэл (төслийн үйл ажиллагаанаас шалтгаална)
Үнэлгээний онцлог	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний дадлага хийхэд ашиглаж болно</li> <li>• Оролцогч талуудыг хамруулсан сургалтанд ашиглаж болно</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн нөлөөллийг харуулсан чанарын болон тоон мэдээлэлд үндэслэнэ</li> <li>• Нийгмийн эрүүл мэндийн ажилтан, судлаач, бодлого хэрэгжүүлэгч, ЭМНҮ-ний туршлагатай хүмүүс үнэлгээг хийнэ</li> </ul>

	Түргэвчилсэн ЭМНҮ	Нарийвчилсан ЭМНҮ
Оролцоог хангах	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талгүй: Төлөвлөгөөний эхний үе шатанд энэ аргыг хэрэглэнэ.</li> <li>Оролцогч талтай: Утсаар ярилцах, цахим шуудан ашиглах, видео хурал гэх мэт мэдээллийн технологиос хамааран оролцогч талуудыг хамруулсан уулзалт зохион байгуулна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Оролцогч талууд бүрэн хамрагдана.</li> </ul> 
Мэдээллийн эх сурвалж	<ul style="list-style-type: none"> <li>Ижил төстэй төслийн үнэлгээний талаарх мэдээлэл болон үр дүнг ашиглах</li> <li>Оролцогч талуудын мэдлэг чадварыг ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шинэ мэдээлэл цуглуулж, боловсруулна</li> <li>Ижил төстэй төслийн үнэлгээний дүн, нотолгоог харьцуулах</li> <li>Оролцогч талуудын мэдлэг чадварыг ашиглах</li> </ul>
Үр дүн	Товч тайлан гаргах	Оролцогч талуудтай хамтран боловсруулсан дэлгэрэнгүй тайлан гаргах

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээнд сонгон ашигласан арга зүй нь үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэж болзошгүй эрүүл мэндийн нөлөөллийн хэмжээ, төлөв байдал, шинж чанарыг бүрэн тодорхойлоход зориулагдсан байх шаардлагатай. Энэ үйл явц нь нөлөөллийг үнэлэх үйл ажиллагаанд зарцуулах нөөцийн (цаг хугацаа, эдийн засаг, мөнгө санхүүгийн) бэлэн байдал, боломжоос хамаарна.

## 2 дугаар үе шат. Цар хүрээг тодорхойлох

Цар хүрээг тодорхойлох үе шат нь эрүүл мэндийн асуудлыг өргөн хүрээтэй хамруулж шинжлэх, ач холбогдлоор нь эрэмбэлэх, эрүүл мэндийн эрсдлийг тодорхойлох, үнэлгээний оновчтой хэлбэрийг сонгох үйл явц юм.

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний нэгдүгээр үе шатанд мэргэжлийн багийн цуглуулсан мэдээллийг энэ шатанд ашиглана. Үнэлгээний хамрах хүрээг тодорхойлох энэ үе шатанд хийх ерөнхий үнэлгээг, төслийн нөлөөллийн хүрээний орон нутагт очиж, үйл ажиллагаа явагдах талбай, тухайн нөхцөл байдалтай биечлэн танилцаж, төсөл хэрэгжүүлэгчид, болон орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж зөвлөлдсөний үндсэн дээр хийж гүйцэтгэнэ. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжих орон нутгийн олон нийт, холбогдох талуудтай зөвлөлдөн, тохиолдож болзошгүй эрүүл мэндийн эерэг болон сөрөг нөлөөллийн цар хүрээг тогтооно. Олон нийтийн оролцооны арга нь тухайн үйл ажиллагааны хүрээнд оролцогч тал бүртэй харилцах, зөвлөлдөх байдлаар тэднийг аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхитэй, хүртээмжтэй оролцох боломжоор хангадаг. Цар хүрээг тодорхойлох үе шатны үр дүнд дор дурьдсан бичиг баримтыг боловсруулсан байна.

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон тайлан
2. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний ажлын даалгавар, удирдамж
3. Холбогдох талуудыг оролцуулах, олон нийттэй зөвлөлдөх төлөвлөгөө.

Хоёрдугаар үе шат нь дараах үйл ажиллагаануудаас бүрдэнэ:


**Үйл ажиллагаа 1.** Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний менежментийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний 1-р үе шатанд хийх үйл ажиллагааны 1-д тодорхойлсон багийн гишүүд үндсэн бүрэлдэхүүнээрээ энэ үе шатанд ажиллаж болно. Хэрэгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны онцлогоос хамаарч шаардлагатай нарийн мэргэжлийн шинжээчдийг нэмж оролцуулна. Түүнчлэн холбогдох талууд тухайлбал, улс төрчид, төсөл хэрэгжүүлэгч (хувийн хэвшлийн байгууллага), нөлөөлөлд өртсөн сонирхогч талууд, холбогдох төрийн байгууллага, асуудал хариуцсан албан тушаалтан, орон нутгийн удирдлага, холбогдох нэгж, тасаг, хэлтэс, эрдэм шинжилгээний, судалгаа, хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн олон нийтийн төлөөллийг хамруулж болно.

Багийн гишүүдийн хийх ажил, үүрэг даалгаврыг тодорхойлон, Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний цар хүрээг нотолгоонд суурилан хийж гүйцэтгэнэ. Иймээс эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг хийх багийн ахлагч эсхүл холбогдох шийдвэр гаргагч нар багийн гишүүдийн ажил, үүргийн тодорхойлолтыг гаргана. Багийн гишүүн тус бүр өөрийн хариуцах даалгаврын санал бэлтгэж, үнэлгээний ажлын даалгавар, удирдамж боловсруулахад оролцоно.

**Үйл ажиллагаа 2.** Цаг хугацаа, газар зүйн хил хязгаарыг тогтоох

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний баг нь санал болгож буй төсөл, хөтөлбөрийн цаг хугацаа, газар зүйн хил хязгаарыг тогтоохдоо үйл ажиллагааны санал болгож байгаа байгууллага, нэгжээс боловсруулж өгсөн бичиг баримт болон ижил, төстэй төслүүдийн талаарх мэдээлэл, орон нутаг, үндэсний болон олон улсын хэмжээнд хийгдсэн судалгаа, үйл ажиллагааны тайланг ашиглана. Санал болгож буй үйл ажиллагааны цаг хугацааг Хүснэгт 2.1-ын дагуу тодорхойлно.



**Хүснэгт 2.1. Үйл ажиллагааны цаг хугацааг тогтоох**

Хэрэгжих цаг хугацаа	
Санал болгож буй байгууллагын хугацааны тооцоолол	ЭМНҮ-ний багийн хугацааны тооцоолол

Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны хүрээнд хамрагдах орон нутгийн газар зүйн хил хязгаарыг тогтоосон мэдээллийг Хүснэгт 2.2-т бүртгэнэ.

**Хүснэгт 2.2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны хүрээнд хамрагдах газар зүйн хил хязгаарыг тогтоох**

Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны хүрээнд хамрагдах газар зүйн хил хязгаар	
Санал болгож буй байгууллагын тооцоолол	ЭМНҮ-ний багийн тооцоолол

**Үйл ажиллагаа 3. Нөлөөлөлд илүү өртөж болзошгүй эмзэг бүлгүүдийг тогтоох.**

Энэ үйл ажиллагааны хүрээнд ЭМНҮ-ний баг нь Хүснэгт 2.3-г ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлд илүүтэй өртөж болох хүн амын эмзэг бүлэг, нөлөөлөх замыг тодорхойлно. Нөлөөллийг 1-4 оноонд үнэлнэ.

Хүснэгт 2.3 Нөлөөлөлд илүү өртөж болзошгүй хүн амын эмзэг бүлэг, нөлөөлөх замыг тогтоох

Нөлөөлөл  Хүн амын бүлэг	Үүсч болох эрүүл мэндийн нөлөөлөл		Эрү үл мэндэд нөлөөлөх зам		Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлд нөлөөлөх байдал				
	Эерэг	Сөрөг	Шууд	Шууд	Хувь хүний зан үйл	Оршин сууж, амьдарч буй орчин	Нийгмийн орчин	Эдийн засгийн орчин	
Өндөр настан									
Эмэгтэйчүүд									
Ажилгүйчүүд									
Гэр оронгүй хүмүүс									
Орлого багатай иргэд									
Өсвөр үеийнхэн									

**Үйл ажиллагаа 4.** Суурь мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Олон улсын, үндэсний болон орон нутгийн хэмжээнд хийгдсэн холбогдох судалгааны тайланг суурь мэдээлэл болгон ашиглаж дүн шинжилгээ хийнэ.


**Үйл ажиллагаа 5.** Эрүүл мэндийн нөлөөллийг ач холбогдол, сөрөг үр дагвараар нь эрэмбэлнэ

Энэ үйл ажиллагааны хүрээнд тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүн амын эрүүл мэндэд учирч болох эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагварыг тодорхойлно.

Эерэг нөлөөлөл: ажлын байрны тоо, орлого нэмэгдсэнээр хүмүүсийн эрүүл мэндээ анхаарах, түүнд зарцуулах санхүүжилт нэмэгдэх зэрэг нөлөөллүүд байна.

Сөрөг нөлөөлөл: бэлчээрийн газар нутаг алдагдах, хүнсний бүтээгдэхүүн, бараа таваарын үнэ нэмэгдэх тохиолдолд нийгмийн эмзэг бүлгийн хүмүүс илүү өртөж, хүн амын бүлэг хоорондын ялгаа ихэсч, зөрчил үүсэх магадлалтай зэрэг нөлөөллүүд байна.

ЭМНУ-ний багийн гишүүд Хүснэгт 2.4-т заасан үзүүлэлтүүдийн дагуу санал болгож үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны хэрэгжилтээс хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг ач холбогдлоор нь, сөргөөр нөлөөлөх үр дагварыг эрсдэлээр нь эрэмбэлнэ. Эрэмбэлэх үйл ажиллагааг төслийн үе шат тус бүрээр гаргана.




Хүснэгт 2.4. Хүн амын эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлээр нь эрэмбэлэх хүснэгт

Төслийн үе шат : 1. Бүтээн байгуулалт 2. Олборлолт 3. Хаалт				
Нөлөөллийн зэрэг	Нөлөөллийн цар хүрээ	Эрчим (Хүн амын дасан зохицох чадвар)	Үргэлжлэх хугацаа	Эрүүл мэндийн нөлөөлөл
Бага (1)	Ховор тохиолдолд	Дасан зохицох чадвар бага зэрэг	Хязгаарлагдмал; сардаа 1-ээс цөөн	Эрүүл мэндэд нөлөөлөх эсэхийг тогтоох боломжгүй
Дунд (2)	Хязгаарлагдмал	Тухайн өртсөн хүн ам дасан зохицох чадвартай	Богино хугацааны: 1 жилээс бага, цөөн давтамжтай	Хөнгөн хэлбэрийн өвчлөл үүсч болно. Эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагагүй.
Өндөр (3)	Олон нийтийг хамарсан. Хязгаарлагдмал	Тухайн өртсөн хүн амын дасан зохицох чадвар сулрах	Дунд хугацааны: 1-6 жил, тасалдсан дамтамжтай	Эрүүл мэндэд нөлөөлнө. Эмнэлгийн тусламж авах шаардлагатай
Маш өндөр (4)	Төслийн хамрах орон нутгийн хүрээнээс гарсан Түгээмэл	Тухайн өртсөн хүн ам дасан зохицох чадваргүй, өвчлөл үүссэн	Урт хугацааны: байнгын дамтамжтай (амь насанд аюултай)	Амь насанд аюул учруулах эрсдэлтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээ зайлшгүй шаардлагатай

**Үйл ажиллагаа 6.** Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлийн эрүүл мэндийн нөлөөлөл, эрсдэл, өөрчлөлтийн эхний таамаглалыг дэвшүүлэх

Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлийн эрүүл мэндийн нөлөөлөл, эрсдэл, өөрчлөлтийн эхний таамаглалыг дэвшүүлэхэд өмнөх үйл ажиллагаанаас гарсан дүгнэлтийг ашиглан дүрслэл зураглалаар гаргаж болно. Үүсэж болох эрүүл мэндийн өөрчлөлтүүдэд дараах зүйлсийг хамруулна:



- 1) Халдварт өвчин
- 2) Бэлгийн замаар дамжих халдвар
- 3) Шинэ хэлбэрийн халдварт өвчин
- 4) Хоол тэжээлийн өөрчлөлт
- 5) Халдварт бус өвчин
- 6) Осол гэмтэл
- 7) Малаас хүнд халддаг өвчин
- 8) Тоосжилт, дуу чимээ, хорт бодис тархах эрсдэл
- 9) Сэтгэцийн эрүүл мэндийн байдал гэх мэт

**3 дугаар үе шат. Дүн шинжилгээ**

Дүн шинжилгээний үе шатанд санал болгож буй төслийг хэрэгжүүлэх орон нутгийн хүн амын эрүүл мэнд, сайн сайхан аж амьдралд учирч болзошгүй эерэг, сөрөг нөлөөллийг системтэйгээр судлах, тэдгээрийн шинж чанар, далайц, хэмжээ, давтамжийг тодорхойлох үйл ажиллагааг хийнэ. Дүн шинжилгээ нь дараах 6 үйл ажиллагаанаас бүрдэх буюу үнэлгээний нэгдүгээр болон хоёрдугаар үе шатанд хийсэн үйл ажиллагаануудыг бүрэн хамруулсан байх шаардлагатай. Үүнд:

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны байдалд шинжилгээ хийх
2. Нөлөөллийн хүрээний орон нутгийн хүн амын эрүүл мэндийн суурь үзүүлэлт, ерөнхий төлөв байдлыг тодорхойлох
3. Холбогдох талууд, гол мэдээлэлтэй хүмүүстэй ярилцлага хийх
4. Эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ, эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийн нотолгоо гаргах
5. Эрүүл мэндийн нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлон ач холбогдлоор нь эрэмблэх
6. Зөвлөмж боловсруулах

Дүн шинжилгээний үе шатанд дараах бичиг баримт боловсрогдсон байна.

1. Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг шинж чанар, ач холбогдлоор нь эрэмбэлэн тогтоосон хүснэгт, тайлан
2. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл ба эрсдэлийг бууруулах талаар гаргасан зөвлөмж

**Үйл ажиллагаа 1.** Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанд шинжилгээ хийх

ЭМНҮ-ний дүн шинжилгээ хийх үе шатны 1-р үйл ажиллагаа болох төслийн шинжилгээг хийхэд тодорхой шаардлагыг ашиглана. Зарим шаардлагыг Хүснэгт 3.1-д үзүүлэв.



Хүснэгт 3.1 Тавигдах шаардлага


Шаардлага	Тийм	Үгүй
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны танилцуулгад тухайн төслийн онцлогын талаар нарийвчлан тодорхойлсон байх		
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны танилцуулгад тухайн төслийн хүрээнд хийх үйл ажиллагааг тусгасан байх **		
ЭМНҮ-ний дүн шинжилгээний үе шатанд зөв, оновчтой арга зүйг ашигласан байх**		
Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны шинжилгээг ЭМНҮ-д тодорхойлсон үе шатны дагуу хийсэн байх		
ЭМНҮ-ний хязгаарлагдмал байдлын талаар мэдээллийг тусгах		

\*\*Тухайн төслийн онцлого болон дүн шинжилгээний үе шатанд ашигласан арга зүйн талаар дэлгэрэнгүй мэдээллэнэ.

**Үйл ажиллагаа 2.** Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн суурь үзүүлэлт, төлөв байдлыг тодорхойлох

Нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн хүн амын эрүүл мэндийн төлөв байдлыг хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтээр гаргана. Үнэлгээний энэ хэсэгт эрүүл мэндийн тэгш бус байдлын асуудлууд, төслийн нөлөөлөлд илүү өртөх магадлалтай эмзэг бүлгүүдийн хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүдийг хамруулна. Үүнд:

- Хүн амын тоо
- Нас, хүйс
- Эрүүл мэндийн байдал



- Тэгш бус байдал (эмзэг өртөмхий хүн амын бүлгүүдийг хамруулах): ядуурал, нийгэм эдийн засгийн байдал, яс үндэс, соёл, ёс заншил, уугуул байдал, газар зүйн байрлал; төслийн нөлөөллийн хүрээнд оршин суудаг, эрүүл мэндийн одоогийн байдал, хөгжлийн бэрхшээл зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан бохирдолт, биофизикийн эрсдэлд өртөх
- Амьдралын нөхцөл, хэв маяг
- Физикийн орчин
- Нийгмийн дэд бүтэц
- Нийгмийн эрүүл мэндийн бодлого, тусламж үйлчилгээний хүртээмж
- Хөдөлмөр эрхлэлт, орчин, засаг захиргааны хяналт, үйлчилгээ

Дээрх тоон мэдээллийг нас, хүйсээр нь ангилна. Энэ шатанд эрүүл мэндийн ерөнхий төлөв байдлыг тодорхойлох, эрүүл мэндийн суурь үзүүлэлтийг боловсруулах үйл ажиллагааг давтан хийнэ. Эхний шатанд, эрүүл мэндийн ерөнхий төлөв байдлыг интернет эх сурвалж, хэвлэлийн тойм, статистикийн тоон мэдээллийг нэгтгэн боловсруулна. Дараагийн шатанд, нэмэлт шаардлагатай мэдээлэл байгаа эсэхийг тодорхойлно. Нэмэлт мэдээлэл цуглуулах шаардлагатай тохиолдолд хоёр дахь мэдээллийн тойм боловсруулна.

**Үйл ажиллагаа 3.** Холбогдох талууд, гол мэдээлэлтэй хүмүүстэй ярилцлага хийх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, эрсдлүүдийг тогтоох, нотолгоо бүрдүүлэх, эрсдлийг дахин эрэмбэлэх үед холбогдох талуудыг оролцуулж олон нийтийн уулзалт, урьдчилан боловсруулсан асуумжийн дагуу бүлгийн болон ганцаарчилсан ярилцлага хийж дүн шинжилгээний зөвлөмжинд оруулна.

**Үйл ажиллагаа 4.** Эрсдлийн үнэлгээ хийх, нөлөөллийг нотлох

Дүн шинжилгээний үе шатанд эрсдлийн үнэлгээ хийж, эрүүл мэндийн сөрөг нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлно. Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлүүдэд сөрөг нөлөө үзүүлэх өөрчлөлтийг урьдчилан тооцоолж хүний эрүүл мэндэд гарах өөрчлөлтийн талаар анхны дэвшүүлсэн таамаглалыг баталгаажуулна. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд чанарын болон тоон судалгааны аргыг хослуулан хэрэглэнэ.

**Үйл ажиллагаа 5.** Эрүүл мэндийн эрсдлийг эрэмблэх

Эрүүл мэндийн нөлөөллийг тодорхойлсны дараа нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлно. Нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлоход ашиглах үзүүлэлтүүдийг Хүснэгт 3.2–т харуулав.

Хүснэгт 3.2 Нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлох

Үзүүлэлт	
Нөлөөллийн шинж чанар	Шууд, шууд бус, хуримтлагдах
Нөлөөллийн чиглэл	Эрүүл мэндийн үр өгөөж (+), эсхүл хохирол (-)
Нөлөөллийн зэрэг	Зэрэг, эрчим, үзүүлэх нөлөөллийн түвшин
Нөлөөллийн далайц	Нөлөөлөлд өртөх хүмүүсийн тоо, орон нутгийн хэмжээ
Хүрээ хязгаар/Байрлал	Газар зүйн байрлалын хүрээ, тархалт
Өртөлтийн түвшин	Давтамж, үргэлжлэх хугацаа, тун хэмжээ  Нөлөөллийн илрэх хугацаа (богино, дунд, урт хугацааны)
Эрсдэлт хүн ам	Тоо хэмжээ, эмзэг өртөмхий байдлын түвшин, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж  Нөлөөллийн тархалтын байдал
Нөлөөллийг саармагжуулж хэвийн байдалд оруулах	Тухайн нөлөөллийг бууруулах, тодорхой хугацааны дараа буцааж эхний байдалд нь оруулах боломж

Эрүүл мэндийн нөлөөллийн шинж чанар, төлөв байдлыг тодорхойлсны дараа тэдгээр нөлөөллийг хэмжээ, далайц, цар хүрээ, ач холбогдлоор нь эрэмблэнэ. Эрэмблэхэд ашиглах үзүүлэлтүүдийг Хүснэгт 3.3 -д харуулав.

Хүснэгт 3.3 Нөлөөллийг ач холбогдлоор нь эрэмбэлэх

Үзүүлэлт	
Өртөлтийн магадлал	Тухайн төслийг хэрэгжүүлэх үед гарсан нөлөөлөл ижил төстэй үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанд илэрвэл магадлалын түвшин ихсэнэ
Нөлөөлөлд өртөмтгий байдал, авах хариу арга хэмжээ	Хүн амын нөлөөлөлд өртөх харьцангуй эмзэг өртөмхий байдал (эдийн засгийн байдал, яс үндэс, хүйс, насны ялгаатай байдал) Нөлөөллийг бууруулах арга хэмжээ авахад бэлэн

	байдлын чадавхи
Эдийн засгийн өртөг зардал	Нөлөөллийг бууруулахад зарцуулах зардал
Хуримтлагдах нөлөөлөл	Тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны нөлөөлөл өөр төслийн нөлөөлөлтэй нэгдэн, хавсарч хуримтлагдах
Нөлөөллийн нийгмийн ач холбогдол	Эрүүл мэндийн тэгш бус байдал, орон нутгийн эдийн засаг, соёлын бүтцэд гарах өөрчлөлтийн түвшин, хэмжээ
Нөлөөллийн нийгмийн эрүүл мэндийн ач холбогдол	Тухайн орон нутагт төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр эрүүл мэндийн нэмэлт ачаалал үүсэх байдал

Нөлөөллийг ноцтой байдал, тохиолдох магадлалын түвшингээр эрэмбэлснийг хүснэгтээр үзүүлнэ.

**Эрсдлийн үнэлгээ**

Үнэлгээ нь 2 хэсгээс бүрдэнэ.

1-р хэсэг нь тухайн нөлөөллийн нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх ач холбогдлыг үнэлж, өвчлөл, нас баралт, хөдөлмөрийн чадвар алдалтын нөлөөллийг тодорхойлно.

2-р хэсэг нь нөлөөллүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэх, бууруулах шаардлагатай эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг тодорхойлж нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НЭМҮАТ) -нд тусгах, нөлөөлөлд өртсөн тусгай халамж шаардлагатай хүн амын эмзэг бүлгүүдийг тодорхойлно.

1 –р хэсэг: Эрүүл мэндийн нөлөөллийн ач холбогдлыг үнэлэх.

Тухайн нөлөөллийн далайц, хамрах хүрээ, тохиолдох магадлал, хэмжээ нь нийгмийн эрүүл мэндийн ач холбогдлыг тодорхойлох үзүүлэлт болдог (нөлөөллийн хэмжээ, эрчим, хугацаа, ноцтой байдлын зэрэг).

Ач холбогдлыг тогтооход дараах асуултанд хариулж үзнэ.

1. Тухайн нөлөөлөлд өртөх магадлалтай хүн амын тоо гарч байна уу?
2. Тухайн нөлөөлөлд өртсөн хүн ам ямар түвшинд дасан зохицох, хариу үйлдэл үзүүлэх чадвартай вэ? Нөлөөлөлд дасах боломж, нөөц байгаа эсэх? Нөлөөллийн хүрээний бүлэг болон хувь хүмүүс, нөлөөлөлд өргөн хүрээтэй өртсөн хүн амтай харьцуулахад тухайн нөлөөлөлд өртөх нь их үү? эсхүл бага уу?

3. Нөлөөллийн үргэлжлэх хугацаа ямар вэ? Төслийн ямар цэгт илүү ноцтой байх вэ? Тохиолдож болох нөлөөллийн үргэлжлэх хугацаа болон давтамжийг тооцох (байнга, тодорхой хугацааны дараа, ховор г.м).
4. Үзүүлж буй нөлөөлөл хир ноцтой болох? (бага зэргийн нөлөө, эмнэлгийн тусламж авах шаардлагатай, хөдөлмөрийн чадвар алдахад нөлөөлөхүйц, амь насанд аюул учруулахуйц г.м).
5. Нийгмийн тулгамдсан асуудлын нэг мөн үү?

Өмнөх асуултуудын хариултыг үндэслэн доорх хүснэгт 3.4-д нөлөөлөлд өртсөн бүлэг хүн амын нөлөөлөл тус бүрийн ач холбогдол, цар хэмжээг урьдчилан тооцно.

Оноо нь 1- 4 хүртэл байна.

Нөлөөллийн хүч нь: 1 = бага аюултай; 2 = дунд аюултай; 3 = их аюултай; 4 = маш их аюултай.

Хүснэгт 3.4 Нөлөөллийн цар хэмжээ, далайцыг тооцох

Нөлөөлөл	Нөлөө өлөлд өртсөн хүн амын дунд эмзэг бүлгийн хүмүүс байгаа эсэхийг тодорхойлно.	Хамрах хүрээ	Эрчим	Хугацаа	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө	Нөлөөллийн далайц / зэрэг буюу - (нийт онооны дундаж)
	Нөлөө өлөл тус бүрээр нь тооцож гаргана.	Бага	Баг	Баг	Баг	
		- 1	а- 1	а - 1	а - 1	
		Дунд	Дун	Дун	Дун	Баг
		- 2	д- 2	д - 2	д - 2	а - 1
		Их	Их	Их	Их	Дун
		3	- 3	- 3	д - 2	Их
		Маш их - 4	Ма ш их - 4	Ма ш их - 4	Ма ш их - 4	Ма ш их - 4

Дээр тодорхойлсон нөлөөллөөс учирч болзошгүй нөлөөлөл тус бүрийг ялгах тэмдэг (х)- ээр тэмдэглэнэ. Шинжлэх ухааны нотолгоо болон мэргэжилтнүүдийн зөвлөмжинд үндэслэн, оролцогч талуудтай зөвшилцөж тухайн нөлөөлөл тохиолдож болох магадлалын түвшинг тогтооно.

Хүснэгт 3.5 Нөлөөллийн магадлалын түвшинг тооцох

Нөлөө өлөл	Нөлөөлөлд өртсөн хүн амын дунд эмзэг бүлгийн хүмүүс байгаа эсэхийг тодорхойлно.	Маш бага Болмооргүй	Бага-Боломжтой	Дунд-Боломжтой	Их-Болон тодорхой
	Нөлөөлөл тус бүрээр нь тооцоог				

	гаргана.				

2-р хэсэг: Эрүүл мэндийн нөлөөллийг эрсдлээр нь эрэмблэнэ.

Хүснэгт 3.4 ба 3.5-д гүйцэтгэсэн тооцоог эрүүл мэндэд нөлөөлөх сөрөг нөлөөллийн багаас ихрүү нь жагсааж нэгтгэнэ.

I – Бага: эрсдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс доогуур эрсдэлтэй ба менежмент шаардаагүй

II – Дунд: эрсдлийн зөвшөөрөгдөх хэмжээтэй давхацсан, байнгын хяналт тавих шаардлагатай

III – Их: эрсдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн, эрчимтэй менежмент шаардлагатай

IV - Маш их: эрсдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс эрс хэтэрсэн, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай

Эрсдлийг дараах томъёогоор тооцно. Эрсдэл = БХ/ХДХ;

БХ – бохирдлын хэмжээ

ХДХ – эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн хүлцэх дээд хэмжээ

$\mathcal{E} < 1$  – ээс бага байх тохиолдолд эрсдэлгүй

$\mathcal{E} = 1$  – тэй тэнцүү байх тохиолдолд эрсдэлтэй

$\mathcal{E} > 1$  – ээс их байх тохиолдолд их эрсдэлтэй

$\mathcal{E} \geq 2$  – оос их буюу тэнцүү байх тохиолдолд маш их эрсдэлтэйд тооцно.

Томъёо ашиглах жишээ: хөрсний мөнгөн усны бохирдлын хэмжээ 6 мг/кг, Монгол улсын стандарт MNS 5850:2008 - д хөрсөнд агуулагдах мөнгөн усны зөвшөөрөгдөх дээд хэмжээ 2 мг/кг гэж байгаа тохиолдолд  $\mathcal{E} = 6/2 = 3$  буюу эрсдэл нь 2-оос их байгаа учир маш их эрсдэлтэй зэрэглэлд тооцогдож байна.

Хүснэгт 3.6 Нөлөөллийн магадлалын зэргийг тооцох

Ф	С	Ф	Ф	С	Ф	Нөлөөллийн магадлалын зэрэг
---	---	---	---	---	---	-----------------------------

			Маш бага – тодорхойлох боломжгүй	Бага – тодорхойлох боломжтой	Дунд – тодорхойлох боломжтой	И – х Илэрхий гарч ирнэ
		1	I	I	I	II
		2	I	II	II	III
		3	II	III	III	IV
		4	III	IV	IV	IV

Дээрх тооцоог ЭМНУ-ний туршид бий болгосон нөлөөллийн үнэлгээний ерөнхий хүснэгт 3.7-д нэмж оруулна. Энэхүү мэдээлэл нь нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад ач холбогдолтой. Төлөвлөх болон үнэлэх хэрэглээнээс хамаараад хүснэгтийн дарааллыг өөрчилж болно (нөлөөллийн категори, эрсдлийн түвшин, нөлөөлөлд өртсөн хүн ам, г.м).

Хүснэгт 3.7 Нөлөөллийн үнэлгээний ерөнхий хүснэгт

Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой өөрчлөлтүүд/ үйл ажиллагаанууд	Төслийн үе шат (бүтээн байгуулалт, олборлолт, нөхөн сэргээх)	Эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлд үзүүлэх нөлөөлөл	Нөлөөлөх замууд	Эрүүл мэндийн байдлын нөлөөллүүд	Нөлөөлөлд илүү өртсөн эмзэг бүлгүүд	Эрсдлийн үнэлгээний хүснэгт (I-IV)-нд тодорхойлсон эрсдлийн түвшин	Мэдээлэл, өгөгдөл, тайлбар
Хүн амын бөөгнөрөл							
Өөрчлөн байршуулах/ нүүлгэн шилжүүлэх							
Усны менежмент							
Зам тээвэр, хобоо							
Аюултай материалуудын хяналт ба устгал							

Өрхийн орлого, зарцуулалтанд гарах өөрчлөлтүүд							
Дэд бүтэц, барилга байгууламжууд							
Бусад							



ЭМНҮ-ний үр дүнг гаргах, мэдээллэх, тайлагнах нь ЭМНҮ-тэй холбоотой харилцаа, мэдээллийн ил тод байдал, олон нийтийн оролцоо, зөвшилцлийг хангаж хэрэгжүүлсэн байдал, үнэлгээний чанар, найдвартай байдлыг хянаж үнэлэхэд чухал шалгуур болно. Энэ нь зөвхөн тусдаа, бие даасан байдлаар хийгдсэн ЭМНҮ-нд хамаараад зогсохгүй, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд, тэдний бүрэлдэхүүн хэсэг байдлаар хийгдсэн ЭМНҮ-ний үр дүнг тайлагнах, мэдээллэх, хяналт тавихад хамаарна. ЭМНҮ-ний үр дүнд үндэслэн боловсруулсан зөвлөмжийн талаар санал хүсэлт, гомдол гарсан тохиолдолд тухайн асуудлыг хэрхэн шийдэх талаар тодорхой мэдээллийг тайланд тусгана.

**Үйл ажиллагаа 6. Зөвлөмж боловсруулах**

Эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах талаар зөвлөмж боловсруулах нь нөлөөллийг тодорхойлж үнэлэхтэй адил чухал ач холбогдолтой. Зөвлөмжинд тусгах асуудлыг сонгохдоо оролцогч талуудтай зөвшилцөж, тэдний саналыг харгалзана. Зөвлөмжөөр санал болгож буй үйл ажиллагаа нь ЭМНҮ-гээр тодорхойлогдож эрэмблэгдсэн, тэргүүлэх зэргийн сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нөлөөллийг авч үзэх ба сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн байна. Эмзэг өртөмхий бүлгийн хүн амд чиглэсэн өвөрмөц үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатай тохиолдолд тэдгээр үйл ажиллагааг зөвлөмжинд тодорхой тусгана.

ЭМНҮ-ний үр дүнд үндэслэн боловсруулсан эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах талаар зөвлөмж боловсруулж холбогдох төсөл хэрэгжүүлэгч, шийдвэр гаргагч нар болон үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн олон нийтэд танилцуулан тэдэнтэй харилцах арга зам, барилыг тодорхой болгоно. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авах арга хэмжээнүүдийн талаар хэлэлцэх уулзалт, ярилцлага хийх төлөвлөгөөг Хүснэгт 3.8-д заасны дагуу боловсруулж, ЭМНҮ-ний даалгавар, зөвлөмжинд хавсаргана.

Хүснэгт 3.8 Холбогдох талуудыг оролцуулах, олон нийттэй зөвлөлдөх төлөвлөгөөний загвар

Олон нийттэй зөвлөлдөх уулзалтууд	Оролцох талууд	Хугацаа	Уулзалт зохион байгуулах газар	Уулзалтын байршил	Хэлэлцэх асуудал	Уулзалтаас гарах шийдвэр, зөвшилцөл

#### 4 дүгээр үе шат. ЭМНУ-ний үр дүн, зөвлөмжийг нягтлан хянах, тайлагнах, мэдээллэх

Энэхүү үе шат нь эрсдэл, нөлөөллийн шинжилгээний үр дүнд үндэслэн боловсруулсан учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг нөлөөлөл үр ашгийг дэлгэрүүлэн нэмэгдүүлэх зөвлөмжийг үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаа хэрэгжүүлэгчид болон шийдвэр гаргагчид, төслийн нөлөөллийн хүрээний орон нутгийн олон нийт, холбогдох талуудад тайлагнаж, мэдээллэх үйл явц юм. Энэ үе шатанд ЭМНУ-ний үйл явцыг баримтжуулан тайланд тусгах, үнэлгээний үнэн бодит байдлыг хянах, нээлттэй ил тод байдлаар хийгдсэн эсэхийг тодорхойлох, үр дүнг мэдээллэх, түгээх зэрэг үндсэн үйл ажиллагааг хийснээр дараах бичиг, баримт боловсрогдсон байна:

1. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үр дүнгийн тайлан

#### 5 дугаар үе шат. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах

Төлөвлөгөөнд үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны улмаас үүсч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, засаж залруулах, зохицуулах, хэрэгжүүлэх арга замууд болон эрүүл мэндийг дэмжих тодорхой үйл ажиллагааг төлөвлөж тусгана. НЭМҮАТ нь ЭМНУ-ний үр дүн, санал зөвлөмж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд холбогдох оролцогч тал тус бүрийн үүрэг хариуцлагыг, нөхцөл байдлын хувилбар тус бүрээр тодорхой тусгаж өгсөн байна. НЭМҮАТ-г хэрэгжүүлэхэд оролцох талуудын санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусгаж өгөх нь чухал. НЭМҮАТ нь аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны үргэлжлэх хугацааны туршид ашиглах, урьдчилан тодорхойлсон эрүүл мэндийн асуудлыг зохистой зохицуулах менежментийн хэрэгсэл ба ЭМНУ-ний салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэхүү төлөвлөгөөг байгаль орчны, нийгмийн болон бусад нөлөөллийн менежментийн төлөвлөгөө, яаралтай тусламжийн болон гамшигийн хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулна. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хүснэгт 5.1-т үзүүлсэн загварын дагуу хийнэ.

## Хүснэгт 5.1. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөний загвар

	Зорилго:					
	Хүрэх үр дүн:					
Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх нэгж/байгууллага	Хэрэгжүүлэх байршил/орон нутаг	Шаардагдах хөрөнгө, нөөц	Шалгуур үзүүлэлт	

Энэ үе шатанд дараах бичиг, баримт боловсрогдсон байна:

1. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө

### 6 дугаар үе шат. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх

НЭМҮ-ний төгсгөлийн үе шатанд хүний эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллийг бууруулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, зорилтот бүлгийнхэнд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хянан үнэлгээ хийж, төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах үйл ажиллагаануудыг хийнэ.

Загвар хүснэгт 6.1-ийг ашиглан нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хянан үнэлгээний хүрээг гаргана.


#### Хүснэгт 6.1. Хяналт үнэлгээний хүрээг тогтоох

Нөлөөллийг бууруулах ажиллагаа үйл ажиллагаа	Зорилтот бүлгийн хүн ам	Үр дүнгийн үзүүлэлтүүд		Үр нөлөөний үзүүлэлтүүд	
		Суурь үзүүлэлтүүд	6-н сарын дараах үзүүлэлт	Суурь үзүүлэлтүүд	6-н сарын дараах үзүүлэлт

#### Г. ЭМНҮ-ний тайланд хавсаргах материалын жагсаалт

1. ЭМНҮ хийх шийдвэр/тушаал

2. ЭМНҮ хийх мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг баталсан шийдвэр/тушаал
3. ЭМНҮ хийх ажлын удирдамж
4. Холбогдох оролцогч талууд болон орон нутгийн иргэдийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэл
5. Төслийн бүх үе шатанд хийсэн дүн шинжилгээний тайлангууд
6. Эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар гаргасан зөвлөмж
7. Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагааны төлөвлөгөө



**Хавсралт 1.** Хүний эрүүл мэндэд нөлөөлөх бохирдуулагчийн хэмжээг тооцох

Хөрсөөр дамжин биед нөлөөлөх бохирдуулагч бодисын тунг дараах томъёогоор тооцно.

$$D_{\text{хөрс}} = IR \times C_{\text{хөрс}} \times AF_{\text{хбэ}} / BW$$

$D_{\text{хөрс}}$  хөрсөөр дамжин хүний биед нөлөөлөх бохирдуулагчийн тунг, мг бохирдуулагч/ биеийн жингийн кг тутамд- өдөрт

$IR$  – хөрсөөр авах хэмжээ, 0,0001 кг/өдөр

$C_{\text{хөрс}}$  – хөрсөнд агуулагдах бохирдуулагчийн хэмжээ, мг/кг

$AF_{\text{хбэ}}$  – хоол боловсруулах эрхтнээр дамжин хүний биед нөлөөлөх фактор, 1,0

$BW$  – биеийн жин, 70 кг

Усаар дамжин хүний биед нөлөөлөх бохирдуулагчийн тунг дараах томъёогоор тооцно.

$$D_{\text{ус}} = IR \times C_{\text{ус}} \times AF_{\text{хбэ}} / BW$$


$D_{yc}$  – усаар дамжин хүний биед нөлөөлөх бохирдуулагчийн тун, мг  
бохирдуулагч / биеийн жингийн кг тутамд- өдөр

IR - усаар авах хэмжээ, 1,4 л/өдөр

$C_{yc}$  – усанд агуулагдах бохирдуулагчийн хэмжээ, мг/л

$AF_{хбэ}$  - хоол боловсруулах эрхтнээр дамжин хүний биед нөлөөлөх фактор, 1,0

BW - биеийн жин, 70 кг



Агаараар дамжин хүний биед нөлөөлөх бохирдуулагчийн тунг дараах томъёогоор тооцно.

$$D_{агаар} = (C \times IR \times EF) / BW$$

$D_{агаар}$  – агаараар дамжин хүний биед нөлөөлөх бохирдуулагчийн тун, мг/кг/өдөр

C – бохирдуулагчийн хэмжээ

IR - амьсгалаар авах хэмжээ, м<sup>3</sup>/өдөр

IR – нярай хүүхэд, 4.5 м<sup>3</sup> / өдөр

IR – 12 -14 насны хүүхэд, 12-15 м<sup>3</sup> / өдөр

IR – насанд хүрсэн хүн, 11.3 – 15.2 м<sup>3</sup> / өдөр

EF – нөлөөллийн фактор,

BW - биеийн жин, 70 кг

**Хавсралт 2. Ном зүй**

Birley, M. (2007). A fault analysis for health impact assessment: procurement, competence, expectations and jurisdictions. *Impact Assessment and Project Appraisal* , 25 (4), 281-289.

Birley, M. (2003). Health impact assessment, integration and critical appraisal. *Impact Assessment and Project Appraisal* , 24 (4), 313-321.

Cave, B., & Curtis, S. (2001). Developing a practical guide to assess the potential health impact of urban regeneration schemes. *Promotion & Education* , 8 (1), 12-16.

Cave, B., Curtis, S., Coutts, A., & Aviles, M. (2001). *Health impact assessment for regeneration projects. Volume II, selected evidence base, breaking the cycle, East London and the City Health Action Zone and Queen Mary*. London: University of London.

Dahlgren, G., & Whitehead, M. (2007). *Policies and strategies to promote social equity in health*. Stockholm: Institute for Futures Studies.

Dalal-Clayton, B., & Bass, S. (2009). *The challenges of environmental mainstreaming: Experience of integrating environment into development institutions and decisions*. London: International Institute for Environment and Development.

European Policy Health Impact Assessment Project. (2004). *European Policy Health Impact Assessment - A guide*. Brussels: European Commission.

Harris, P. J., Harris, E., Thompson, S., Harris-Roxas, B., & Kemp, L. (2009 оны September). Health and wellbeing in environmental environmental impact assessment in New South Wales, Australia: Auditing health impacts within environmental assessments of major projects. *Environmental Impact Assessment Review* , 29 (5), pp. 310-318.

International Finance Corporation. (2009). *Introduction to Health Impact Assessment*. Washington D.C.: IFC.

Ison, E. (2008). *Integrating HIA or a concern for health into environmental impact assessments*. Geneva: unpublished.

Joffe, M., & Mindell, J. (2002). A framework for the evidence base to support health impact assessment. *Journal of Epidemiology and Community Health* , 132-138.

Joffe, M., & Mindell, J. (2005). Health Impact Assessment. *Occupational and Environmental Medicine* , 62, 907-912.

Listorti, J. A., & Doumani, F. M. (2001). *Environmental Health: Bridging the Gaps, Issue 422*. Washington D.C.: World Bank.

Mindell, J., Ison, E., & Joffe, M. (2003). A glossary for health impact assessment. *Journal of Epidemiology and Community Health* , 57, 647-651.

Ministry of Environment and Green Development. (2012). *Amended Law on Environmental Assessment ('EIA Law')*. Ulaanbaatar: Government of Mongolia.

MoH HIA Technical Working Group. (2011). *Health Impact Assessment: Background, methods and tools for the Mongolian mining sector*. Ulaanbaatar.

Morgan, R. K. (2011 оны July). Health and impact assessment: Are we seeing greater integration? *Environmental Impact Assessment Review* , 31 (4), pp. 401-411.

Pfeiffer, M., & Dora, C. (2009). *Health impact assessment in development lending - a reference guide and discussion draft*. Geneva: World Health Organization.

Quigley, R., den Broder, L., Furu, P., Bond, A., Cave, B., & Bos, R. (2006). *Health Impact Assessment International Best Practice Principles*. Fargo: International Association for Impact Assessment.

Scott-Samuel, A., Birley, M., & Ardern, K. (2001). *The Merseyside Guidelines for Health Impact Assessment*. Liverpool: International Health Impact Assessment Consortium.

Stakeholder Participation Working Group of the 2010 HIA in the Americas Workshop. (2012). *Best Practices for Stakeholder Participation in Health Impact Assessment*. Oakland.

Tamburrini, A., Gilhuly, K., & Harris-Roxas, B. (2001 оны September 1). Enhancing benefits in health impact assessment through stakeholder consultation. *Impact Assessment and Project Appraisal* , pp. 00-00.

Whitehead, M., & Dahlgren, G. (1990). *The concepts and principles of equity and health*. Copenhagen: World Health Organization Regional Office for Europe.

WHO European Centre for Health Policy. (1999). *Health Impact Assessment: main concepts and suggested approach. Gothenburg Consensus Paper*. Gothenburg: WHO Regional Office for Europe.

World Health Organization. (1946). *Constitution*. Geneva: World Health Organization.

World Health Organization Regional Office for Europe. (2005). *Health Impact Assessment Toolkit for Cities. Document 1*. Denmark: WHO Regional Office for Europe.

1.  $\frac{1}{x^2} = x^{-2}$   
 $\frac{d}{dx} x^{-2} = -2x^{-3} = -\frac{2}{x^3}$

2.  $\frac{d}{dx} \frac{1}{x^3} = \frac{d}{dx} x^{-3} = -3x^{-4} = -\frac{3}{x^4}$

3.  $\frac{d}{dx} \frac{1}{x^4} = \frac{d}{dx} x^{-4} = -4x^{-5} = -\frac{4}{x^5}$

4.  $\frac{d}{dx} \frac{1}{x^5} = \frac{d}{dx} x^{-5} = -5x^{-6} = -\frac{5}{x^6}$